



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 53

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2.4, 5.8.в дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өндөршил сумын ЗДТГ-ын хуучин барилгын өргөтгөл 3'050'350 /гурван сая тавин мянга гурван зуун тавин/ төгрөгийн хөрөнгийг акталж устган, барилга байгууламж акталснаас гарах материалыг байгууллагын эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгө актлах ажлыг сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данснаас хасч, гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг Өндөршил сумын ЗДТГ /Б.Амгаланжаргал/-т даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100126